



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 04 өдөр

Дугаар А/240

Алтай хот

Өндөржүүлсэн бэлэн байдлын үед
зохион байгуулалтын арга хэмжээ
авах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.3 дахь заалт, Засгийн газрын 2021 оны 154 дүгээр тогтоол, аймгийн Онцгой комиссын 2021 оны 32 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1."Алтайн хүдэр" ХХК-ий хүдрийн уурхайд коронавирусын тохиолдол бүртгэгдсэнтэй холбогдуулан үйл ажиллагааг 2021 оны 06 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл бүрэн зогсоож, Цээл сумын Эрүүл мэндийн төвөөс эмч, сувилагч, үйлчлэгч, ариутгалын 4 ажилтанг улаан буюу халдвартай бүсэд ажиллуулах, үйл ажиллагаатай холбоотой зардлыг "Алтайн хүдэр" ХХК-аар гаргуулж, ажилчдаас нэг бүрчлэн шинжилгээ авах зэрэг холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа З.Баттулга), Цагдаагийн газар (хурандаа Н.Эрдэнэ-Очир), Эрүүл мэндийн газар (Ц.Туяа), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар) нарт тус тус даалгасугай.

2.Говь-Алтай аймгийн Есөнбулаг сумын Төрийн банкны үйл ажиллагааг 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс 06 дугаар сарын 07-ны өдрийг хүртэл бүрэн зогсоож ажиллахыг Цагдаагийн газар (хурандаа Н.Эрдэнэ-Очир), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар) нарт тус тус даалгасугай.

3.Баянхонгор аймгийн Бууцагаан, Ховд аймгийн Дарив сумдад ажиллаж байгаа хяналтын цэгүүдийг 2021 оны 06 дугаар сарын 04-ний өдрөөс буулгаж,


2.

Есөнбулаг сумын гарах, орох цэгүүдэд хүч нэмэгдүүлэн ажиллуулах, түргэвчилсэн шинжилгээний оношлуурыг худалдан авах үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах, бэлтгэл бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Онцгой байдлын газар (хурандаа З.Баттулга), Цагдаагийн газар (хурандаа Н.Эрдэнэ-Очир), Эрүүл мэндийн газар (Ц.Туяа), Мэргэжлийн хяналтын газар (Н.Сумъяабазар) нарт тус тус даалгасугай.

4.Нийтийн хоол үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллага, иргэдийг түргэвчилсэн шинжилгээнд хамруулахыг Эрүүл мэндийн газар (Ц.Туяа)-т даалгасугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР